

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2026/166/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

Audit.mn

Хэнтий аймаг

Чингис хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 мэйл хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 мэйл хаяг: Oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энх-Амгалан
Утас: 91119424 мэйл хаяг: Enkh-Amgalang@audit.gov.mn

Ари файнэнс аудит ХХК-ийн Захирал: Д.Ариунаа
Утас: 99088151 мэйл хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. \



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.24 № 276

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1.8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр буюу 8 хоногоор хоцроож ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч...жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ,” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, хэмжилт, эрх үүрэг, оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Дээрх зөрчлийг давтан гаргавал албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 34,465.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 27,970.1 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан, 1,637.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 4,695.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний 26 зорилтын хүрээнд 68 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэл 83.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж. ГАНБААТАР

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 281,363,500.35 | 299,136,374.23 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 135,847,127.53 | 157,714,182.61 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 135,847,127.53 | 157,714,182.61 |
| 31210 | Төгрөг | 135,847,127.53 | 157,714,182.61 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 135,847,127.53 | 157,714,182.61 |
| 33 | АВЛАГА | 12,306,382.30 | - |
| 33500 | Бусад авлага | 12,306,382.30 | - |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 12,306,382.30 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 133,209,990.52 | 141,422,191.62 |
| 35100 | Түүхий эд материал | 7,862,751.90 | 18,225,418.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 7,862,751.90 | 18,225,418.00 |
| 35400 | Хангамжийн материал | 125,347,238.62 | 123,196,773.62 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,246,505.64 | 6,734,705.64 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,169,135.00 | 15,763,035.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 330,000.00 | |
| 35450 | Барилгын засварын материал | 4,083,500.00 | 500,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,230,550.00 | 3,514,985.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 90,092,547.98 | 91,989,047.98 |
| 35600 | Мал амьтад | 5,195,000.00 | 4,695,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,257,915,516.76 | 8,399,298,932.26 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,257,915,516.76 | 8,399,298,932.26 |
| 39200 | Биет хөрөнгө | 1,205,835,516.76 | 8,347,218,932.26 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,040,384,757.00 | 8,774,998,420.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (220,672,178.45) | (780,101,890.09) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 376,034,732.01 | 349,225,197.01 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (139,063,270.49) | (117,326,127.58) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 172,196,355.43 | 142,371,217.64 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (52,886,553.87) | (36,775,572.12) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 30,104,310.00 | 30,104,310.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (21,555,066.72) | (25,526,608.80) |
| 39217 | Ном | 21,292,431.85 | 10,249,986.20 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 52,080,000.00 | 52,080,000.00 |
| 39301 | Програм хангамж | 922,600.00 | - |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (922,600.00) | - |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 52,080,000.00 | 52,080,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 1,539,279,017.11 | 8,698,435,306.49 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 86,499.75 | 12,664,404.69 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 86,499.75 | 12,664,404.69 |
| 41300 | Өглөг | 86,499.75 | 12,664,404.69 |
| 41360 | Бусад өглөг | 86,499.75 | 12,664,404.69 |
| 41310 | Ажилчдтай холбогдсон өглөг | | 10,010,719.69 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 86,499.75 | 2,653,685.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,539,192,517.36 | 8,685,770,901.80 |

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------------|--|-------------------------|-------------------------|
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,539,192,517.36 | 8,685,770,901.80 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 766,199,791.75 | 766,199,791.75 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 766,199,791.75 | 766,199,791.75 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 637,244,644.85 | 7,775,547,029.29 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 277,587,791.26 | 626,114,199.20 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 359,656,853.59 | 7,149,432,830.09 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 135,748,080.76 | 144,024,080.76 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 1,539,279,017.11 | 8,698,435,306.49 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|---|-------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 2,201,223,978.10 | 9,439,039,530.91 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 353,660,178.10 | 7,321,185,230.91 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 353,660,178.10 | 7,321,185,230.91 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,585,000.00 | 3,294,800.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,585,000.00 | 444,800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.00 | 2,850,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 339,459,108.90 | 7,305,867,265.06 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 9,616,069.20 | 12,023,165.85 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,847,563,800.00 | 2,117,854,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,456,186,700.00 | 1,707,125,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,456,186,700.00 | 1,707,125,500.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх | 391,377,100.00 | 410,728,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн/ | 391,377,100.00 | 410,728,800.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,841,567,124.31 | 2,289,606,700.82 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,841,567,124.31 | 2,289,606,700.82 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,767,105,444.05 | 2,182,188,576.06 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,082,018,861.41 | 1,319,738,483.25 |
| 210101 | Үндсэн цалин | 714,111,724.11 | 798,540,955.12 |
| 210102 | Нэмэгдэл | 302,741,077.30 | 394,551,588.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 30,480,000.00 |
| 210104 | Урамшуулал | 65,166,060.00 | 96,165,940.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 139,573,334.36 | 163,829,757.88 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 97,481,438.85 | 112,391,260.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 10,837,409.21 | 13,214,665.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 5,590,047.27 | 6,841,261.34 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 5,132,887.82 | 6,276,514.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 20,531,551.21 | 25,106,055.84 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 388,235,462.74 | 398,200,140.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,794,070.74 | 22,508,748.24 |
| 210302 | Түлш, халаалт | 366,241,392.00 | 366,241,392.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,200,000.00 | 9,450,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 20,194,680.00 | 26,102,171.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,194,680.00 | 26,102,171.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 829,709.00 | 6,012,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 829,709.00 | 6,012,000.00 |

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------|-------------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,395,209.10 | 33,608,614.78 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,579,500.00 | 2,624,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,815,709.10 | 30,984,014.78 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 124,858,187.44 | 234,697,408.91 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,684,395.22 | 42,467,430.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,220,660.00 | 2,542,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 88,953,132.22 | 189,687,478.91 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 74,461,680.26 | 107,418,124.76 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 74,319,892.00 | 104,889,465.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 51,923,460.00 | 85,248,765.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22,396,432.00 | 19,640,700.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 141,788.26 | 2,528,659.76 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 141,788.26 | 2,528,659.76 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 359,656,853.79 | 7,149,432,830.09 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 359,656,853.79 | 7,149,432,830.09 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|---|-------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 1,852,148,800.00 | 2,121,149,100.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,585,000.00 | 3,294,800.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,585,000.00 | 3,294,800.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,585,000.00 | 3,294,800.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,585,000.00 | 444,800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.00 | 2,850,000.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого /орон нутаг/ | 391,377,100.00 | 410,728,800.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,456,186,700.00 | 1,707,125,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,456,186,700.00 | 1,707,125,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,456,186,700.00 | 1,707,125,500.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,811,445,818.14 | 2,071,311,969.92 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,811,445,818.14 | 2,071,311,969.92 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,734,465,487.88 | 1,967,783,410.16 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,062,198,776.42 | 1,304,203,198.25 |
| 210101 | Үндсэн цалин | 659,005,068.99 | 766,492,014.20 |
| 210102 | Нэмэгдэл | 319,973,020.68 | 420,362,404.11 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 30,480,000.00 |
| 210104 | Урамшуулал | 83,220,686.75 | 86,868,779.94 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 160,076,355.40 | 167,499,940.89 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 116,573,867.43 | 114,396,141.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 10,957,071.03 | 13,360,039.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 5,539,998.83 | 6,740,224.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 5,401,044.04 | 6,600,766.96 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 21,604,374.07 | 26,402,767.69 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 388,235,462.74 | 398,200,140.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,794,070.74 | 22,508,748.24 |

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------|------------------------|
| 210302 | Түлш, халаалт | 366,241,392.00 | 366,241,392.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,200,000.00 | 9,450,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 19,626,880.00 | 27,713,086.00 |
| 210502 | Хоол, хүнс | 19,626,880.00 | 27,713,086.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,999,849.00 | 10,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,999,849.00 | 10,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 25,756,754.32 | 22,176,814.78 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,542,090.00 | 444,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 23,214,664.32 | 21,732,014.78 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 75,571,410.00 | 37,990,230.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 65,234,510.00 | 29,828,230.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,336,900.00 | 8,162,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 76,980,330.26 | 103,528,559.76 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 76,838,542.00 | 103,528,559.76 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 54,442,110.00 | 81,359,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22,396,432.00 | 19,640,700.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 141,788.26 | 2,528,659.76 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 141,788.26 | 2,528,659.76 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 40,702,981.86 | 49,837,130.08 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | - | 27,970,075.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 27,970,075.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 27,970,075.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 27,970,075.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | - | (27,970,075.00) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 40,702,981.86 | 21,867,055.08 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 95,144,145.67 | 135,847,127.53 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 135,847,127.53 | 157,714,182.61 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|------------|--|---------------------------------|-----------------------|----------------------|--|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 766,199,791.75 | 135,748,080.76 | 637,156,644.85 | 1,539,104,517.36 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | (11,042,445.65) | (11,042,445.65) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 766,199,791.75 | 135,748,080.76 | 626,114,199.20 | 1,528,062,071.71 |

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|----|---|----------------|----------------|------------------|------------------|
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | 8,276,000.00 | | 8,276,000.00 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 766,199,791.75 | 144,024,080.76 | 626,114,199.20 | 1,536,338,071.71 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 766,199,791.75 | 144,024,080.76 | 626,114,199.20 | 1,536,338,071.71 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | | | 7,149,432,830.09 | 7,149,432,830.09 |
| 20 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 766,199,791.75 | 144,024,080.76 | 7,775,547,029.29 | 8,685,770,901.80 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|------------|---|-------------------------|-------------------------|-----------------------|-------------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 2,135,096,900.00 | 2,118,620,440.24 | 15,338,459.76 | 99.3 |
| 12 | Татварын бус орлого | 2,135,096,900.00 | 2,118,620,440.24 | 15,338,459.76 | 99.3 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,432,800.00 | 3,294,800.00 | 1,138,000.00 | 74.3 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 444,800.00 | 444,800.00 | - | 100.0 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 3,988,000.00 | 2,850,000.00 | 1,138,000.00 | 71.5 |
| 122 | Тусламжийн орлого | 2,130,664,100.00 | 2,115,325,640.24 | 15,338,459.76 | 99.3 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,719,935,300.00 | 1,707,125,500.00 | 12,809,800.00 | 99.3 |
| 122005 | Төсвөөс санхүүжих /орон нутаг/ | 410,728,800.00 | 408,200,140.24 | 2,528,659.76 | 99.4 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,270,143,700.00 | 2,096,753,385.16 | 173,390,314.84 | 92.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,270,143,700.00 | 2,096,753,385.16 | 173,390,314.84 | 92.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,164,602,900.00 | 1,995,753,485.16 | 168,849,414.84 | 92.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,451,923,100.00 | 1,304,203,198.25 | 147,719,901.75 | 89.8 |
| 210101 | Үндсэн цалин | 854,821,600.00 | 766,492,014.20 | 88,329,585.80 | 89.7 |
| 210102 | Нэмэгдэл | 529,688,700.00 | 420,362,404.11 | 109,326,295.89 | 79.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 30,480,000.00 | (30,480,000.00) | |
| 210104 | Урамшуулал | 67,412,800.00 | 86,868,779.94 | (19,455,979.94) | 128.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 181,490,300.00 | 167,499,940.89 | 13,990,359.11 | 92.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 123,413,500.00 | 114,396,141.49 | 9,017,358.51 | 92.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,519,300.00 | 13,360,039.84 | 1,159,260.16 | 92.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,259,500.00 | 6,740,224.91 | 519,275.09 | 92.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,259,500.00 | 6,600,766.96 | 658,733.04 | 90.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 29,038,500.00 | 26,402,767.69 | 2,635,732.31 | 90.9 |

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|-------------|--|-------------------------|------------------------|---------------------|--------------|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 400,728,800.00 | 398,200,140.24 | 2,528,659.76 | 99.4 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,037,400.00 | 22,508,748.24 | 2,528,651.76 | 89.9 |
| 210302 | Түлш, халаалт | 366,241,400.00 | 366,241,392.00 | 8.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,450,000.00 | 9,450,000.00 | - | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 27,832,700.00 | 27,713,086.00 | 119,614.00 | 99.6 |
| 210502 | Хоол, хүнс | 27,832,700.00 | 27,713,086.00 | 119,614.00 | 99.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,000,000.00 | 10,000,000.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 10,000,000.00 | - | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 25,279,800.00 | 22,176,814.78 | 3,102,985.22 | 87.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 487,700.00 | 444,800.00 | 42,900.00 | 91.2 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 24,792,100.00 | 21,732,014.78 | 3,060,085.22 | 87.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 67,348,200.00 | 65,960,305.00 | 1,387,895.00 | 97.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 59,186,200.00 | 57,798,305.00 | 1,387,895.00 | 97.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,162,000.00 | 8,162,000.00 | - | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 105,540,800.00 | 100,999,900.00 | 4,540,900.00 | 95.7 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 105,540,800.00 | 100,999,900.00 | 4,540,900.00 | 95.7 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 85,900,100.00 | 81,359,200.00 | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 19,640,700.00 | 19,640,700.00 | - | 100.0 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | (268,081,600.00) | 21,867,055.08 | | |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 268,081,600.00 | (53,146,554.46) | | |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 268,081,600.00 | (53,146,554.46) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 135,847,127.53 | | |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 157,714,182.61 | | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 94 | 94 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 31 | 31 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 11 | 11 | - | 100.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 93 | 93 | - | 100.0 |
| 650004 | СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч | 29 | 29 | - | 100.0 |
| 650009 | Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 14 | 14 | - | 100.0 |

| | | | | | |
|----|--------------------------|---|---|---|-------|
| 66 | НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ | 3 | 3 | - | 100.0 |
|----|--------------------------|---|---|---|-------|

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 34,465.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 27,970.1 мянган төгрөгийн 1 алдаа¹ аудитын явцад залруулж, 162.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1,637.0 мянган төгрөгийн зөрчилд² 3 албан шаардлага, 4,695.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

3.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант онд худалдаж авсан 27,970.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа үйлчилгээний зардлаар бүртгэсэн.

Аудитаар нийт 6,494.9 мянган төгрөгийн 5 зөрчил³ илэрснээс, 162.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 1,637.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 4,695.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн 6,494.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.2 Төлбөрийн акт

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон нэг ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл цалин 162.9 мянган төгрөг олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон. Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

3.3 Албан шаардлага

1. Аудитын дүгнэлт өөрчлөлтгүй, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт хангалттай үнэлэгдсэн гэсэн үзүүлэлтээр 1 ажилтанд 20 хувиар 5 сарын ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”, “сумын түвшинд 15 хувь,” аймаг,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нийслэлийн түвшинд 20 хувь, ” улс, бүс, олон улсын амжилт гаргасан түвшинд 25 хувь, ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн. Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

2. Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалтууд, санхүүгийн тайлангийн "үнэлгээ", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн. Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

3. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.1-д "бие даасан байх", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", 15.2- т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн "үнэлгээ", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн. Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

3.4 Зөвлөмж

1. Тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Малын дансанд бүртгэлтэй малын орлого зарлагатай холбоотой анхан шатны баримт материалыг аудитад ирүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу малын хорогдлыг хүлээн зөвшөөрч бүртгэлээс хассан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэх, бүртгэл тайланд тусгахыг хориглоно", 4 дүгээр зүйлийн 4.2.1.1.нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй; Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т"Төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх;" гэж заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх" "үнэн зөв байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж, малын тооцоог хийж байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----------------|------------|-----------------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Тайлант онд худалдаж авсан үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа үйлчилгээний зардлаар бүртгэсэн. | 1 | 27,970.1 | | | 1 | 27,970.1 | 1 | 27,970.1 | | | | |
| Дүн | 1 | 27,970.1 | | | 1 | 27,970.1 | 1 | 27,970.1 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|---------|---------------|-------|-----------------|---------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон нэг ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл цалин 162.9 мянган төгрөг олгосон байна. | 1 | 162.9 | 1 | 162.9 | | | | | | | | |
| Аудитын дүгнэлт өөрчлөлтгүй, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт хангалттай үнэлэгдсэн гэсэн үзүүлэлтээр 1 ажилтанд 20 хувиар 5 сарын ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүй олгосон байна. | 1 | 1,637.0 | | | 1 | 1,637.0 | | | | | | |
| Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | |
|---|----------|----------------|----------|--------------|----------|----------------|----------|----------------|--|--|--|--|
| Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна. | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |
| Малын дансанд бүртгэлтэй малын орлого зарлагатай холбоотой анхан шатны баримт материалыг аудитэд ирүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу малын хорогдлыг хүлээн зөвшөөрч бүртгэлээс хассан байна. | 1 | 4,695.0 | | | | | 1 | 4,695.0 | | | | |
| Дүн | 5 | 6,494.9 | 1 | 162.9 | 3 | 1,637.0 | 1 | 4,695.0 | | | | |